



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 21

Эрдэнэт

Ой тэмдэглэх тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн төв Эрдэнэт хот байгуулагдсаны 40 жилийн ойн баяр наадмын чанартай арга хэмжээнүүдийг Аймгийн баяр наадамтай хамтатган зохион байгуулахаар, бусад ёслол хүндэтгэл, зохион байгуулалтын нэгдсэн үйл ажиллагааг 2016 оны 5 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус тогтоосугай.


2. Аймгийн Засаг даргын орлогч, Эрдэнэт хот байгуулагдсаны 40 жилийн ойг тэмдэглэх ажлын бэлтгэл зохион байгуулалтыг хангах хорооны дарга Д.Энхбатад ДААЛГАХ нь:

2.1. Хот байгуулагдсаны 40 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж буй ажлыг бүх чиглэлээр идэвхжүүлж, мэдээллээр хангаж ажиллах.

2.2. Энэхүү тогтоолыг Засгийн газарт хүргүүлж шийдвэр гаргуулах, дэмжлэг авах ажлыг зохион байгуулах.

2.3. Хотын нийт байгууллага иргэдийн хүч анхаарлыг ойн арга хэмжээнд нэгтгэн чиглүүлж, тэдний бүтээлч идэвхийг өрнүүлэх замаар оролцоог хангаж ажиллах.

2.4. Эрдэнэт хотын 40 жилийн ойг бэлтгэл зохион байгуулалтын өндөр хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлганах.



C:\Togtool \A4 doc

• 00100009